



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

“Сэлэнгэ дулаанхаан” ХК-ийн үнэт
цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 162 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өвлүүлэх тухай журам”-ын 1.12, 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн, “Сэлэнгэ дулаанхаан” ХК-ийн үнэт цаасны арилжааг Хорооны шийдвэрээр зогсоосон байгааг тэмдэглэн, Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэ тогтоолын хавсралтад дурьдсан нэр бүхий зургаан иргэний өмчлөлийн “Сэлэнгэ дулаанхаан” ХК-ийн нийт 66,458 ширхэг энгийн хувьцааны өмчлөх эрхийг тэдгээрийн гаргасан хүсэлтийн дагуу тус компанийн хувьцаа эзэмшигч Б.Баярсайханд 35,164, Б.Отгонцэцэгт 31,294 ширхэгээр тус тус шилжүүлэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

2. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бэлэглэлийн журмаар шилжүүлэх ажиллагааг холбогдох журмаар тогтоосон нөхцөл шаардлагын дагуу гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.


ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000067

Санхүүгийн зохицуулах хорооны
2013 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
211 дүгээр тогтоолын хавсралт



Хэнээс			Хэнд			
Нэр	Дансны дугаар	Хувьцааны тоо /ширхэг/	Нэр	Дансны дугаар	Хувьцааны тоо /ширхэг/	
1.	Л.Чулуунхүү	02-16155	18,469	Б.Баярсайхан	02-241265	18,469
2.	Ш.Цэдэндаш	02-223647	15,378	Б.Баярсайхан	02-241265	15,378
3.	А.Хишигдорж		1,317	Б.Баярсайхан	02-241265	1,317
4.	О.Батмөнх	02-260306	16,691	Б.Отгонцэцэг	02-250099	16,691
5.	С.Болортуяа	02-232021	9,729	Б.Отгонцэцэг	02-250099	9,729
6.	Т.Батбаяр	02-260144	4,874	Б.Отгонцэцэг	02-250099	4,874
Нийт хувьцаа		66,458	Нийт хувьцаа		66,458	

-----oOo-----